



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Гэр хороолол хөгжлийн нам (ГХХН)-ын
дарга болон дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Гэр хороолол хөгжлийн нам (ГХХН)-ын дарга болон тус намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг Танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Гэр хороолол хөгжлийн намын үүсгэн байгуулагч Б.Батсүхээс "... намын 3 дугаар Их хурал 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж, санал хураалтад оролцсон 98 төлөөлөгчийн 66 санал буюу 67.3 хувийн саналаар намын даргаар Б.Батсүхийг сонгож, Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Иймд тус өөрчлөлтүүдийг бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийж өгнө үү" гэх өргөдлийг 125 хуудас баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ (эх хувь), 2 ширхэг флашны хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан "Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам"-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба тухайн ажиллагааны явцад нэмэлтээр ирүүлсэн 38 хуудас баримтыг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Гэр хороолол хөгжлийн намын даргаар Батхуягийн Батсүхийг болон намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг тус тус бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг.Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан процессын талаар:

Гэр хороолол хөгжлийн намын дүрмийн (цаашид “Дүрмийн” гэх) 6.27.2-т “Намын Бага хурлын хуралдааныг “Гэр хороолол хөгжлийн нам”-ын дарга, ... зарлан хуралдуулж болно”, 6.25.1-д “Намын Их хурлаас Бага хурлыг 31 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаагаар байгуулна. Бага хурлын төлөөлөгчдийг намын Их хурлаас нээлттэй нэр дэвшүүлж, нууц санал хураалтаар сонгоно”, 6.27.4-т “Бага хурлын гишүүдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол намын Бага хурлыг хүчинтэйд тооцно”, 6.23.2-т “Намын ээлжит болон ээлжит бус Их хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг хуралдах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд намын Их хурлын тов, төлөөлөгчдийн тоог Бага хурлаар тогтооно” гэж тус тус заажээ.

Түүнчлэн, Гэр хороолол хөгжлийн намын хувийн хэргээс үзэхэд, намын үүсгэн байгуулах Анхдугаар хурлын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолоор намын Бага хуралд 31 гишүүний нэрийг баталсан байна.

Өргөдөлд хавсаргаж ирүүлсэн баримтуудаас үзвэл, Гэр хороолол хөгжлийн намын дарга Б.Батсүхийн 2025 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 209 дүгээр албан бичгээр тус намын Бага хурлыг 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдөр намын байранд хуралдуулахаар зарлаж, хэлэлцэх асуудлыг тогтоосон, Бага хурлын 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралд 31 гишүүнээс 23 гишүүн оролцсон гэх ба гишүүдийн нэрсийг дээр дурдсан 07 дугаар тогтоолоор баталсан 31 гишүүний нэртэй тулгахад бүгд таарсан тул хуралд оролцох эрх бүхий этгээдүүд оролцсон, Дүрмийн 6.27.4-т заасан шаардлагыг хангасан гэж үзэх үндэслэлтэй, тухайн Бага хурлын хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзлээ.

Улмаар Гэр хороолол хөгжлийн намын Бага хурлын 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хурлын 05 дугаар тогтоолоор намын 3 дугаар Их хурлыг 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулахаар товлон зарлаж, 3 дугаар Их хурлын төлөөлөгчийг 120 байхаар тогтоосон нь дүрмийн 6.23.2 дахь заалттай нийцсэн байна.

Гэр хороолол хөгжлийн намын 3 дугаар Их хурлын 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд Их хурлын төлөөлөгчөөр сонгогдсон 120 төлөөлөгчөөс 119 оролцсон нь (орон нутгаас 6 төлөөлөгч) дүрмийн 6.23.1-д “Намын Их хуралд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол Их хурлыг хүчинтэйд тооцох” гэж заасантай мөн нийцжээ.

Харин, уг Их хурлын төлөөлөгчдийн ирцийг баталгаажуулах зорилгоор ирүүлсэн иргэний үнэмлэхийн хуулбарууд дотор насанд хүрээгүй (2008, 2009 оны) 4 хүний иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсарган ирүүлсэн “зөрчил” илэрсэн хэдий ч уг 4 насанд хүрээгүй хүнийг хурлын ирц болон санал хураалтын дүнгээс хасаж тооцсон ч ирц болон бусад байдалд нөлөөлөхөөргүй байх тул уг зөрчил нь Их хурлаас гаргасан шийдвэрийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй, хурлыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй гэж үзэв.

Мөн Гэр хороолол хөгжлийн намаас ирүүлсэн өргөдөлд намын 3 дугаар Их хурлын төлөөлөгчийг хэрхэн сонгосон болон хурлын зарыг төлөөлөгчдөд хэрхэн

хүргэсэн талаарх баримт ирүүлээгүй, энэ талаар тус намаас тодруулахад, 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 264 дүгээр албан бичгээр "... Гэр хороолол хөгжлийн намын төлөөлөгчдийг сонгохдоо Улаанбаатар хот болон орон нутгаас намын үйл ажиллагаанд анхнаас нь идэвх зүтгэл гаргаж, үнэт зүйл, үзэл санаа, үйл хэргийг түгээн дэлгэрүүлж ирсэн ахмад үеийн төлөөлөл, залуу үеийн төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болсон намын гишүүдийг оролцуулахаар сонгож утсаар мэдэгдэж зар хүргүүлсэн. Энэ тухай "inews.mn" сайтад нийтэлж мэдээлсэн. ..." гэх тайлбар ирүүлснийг "хуульд нийцэхгүй" гэж үзэх үндэслэлгүй байна.

Хоёр.Намын Их хурлаас намын даргыг сонгож, баталсан талаар:

Намын хувийн хэрэгт хадгалагдаж буй баримтад намын үүсгэн байгуулах Анхдугаар хурлыг 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, тус хурлын 08 дугаар тогтоолоор намын даргаар Батхуягийн Батсүхийг сонгосон боловч тухайн үед намын даргыг бүртгүүлэх хүсэлтийг Улсын дээд шүүхэд гаргаагүй, Улсын дээд шүүхийн тогтоолоор бүртгэгдээгүй байжээ.

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д "намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно" гэж заасан, түүнчлэн Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Гэр хороолол хөгжлийн намын дүрмийн 2.2-т "Гэр хороолол хөгжлийн нам ... үйл ажиллагаагаа ил тод явуулах, гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход ... адил тэгш боломж олгох, намын дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхын саналаар шийдвэрлэж байх, ... зарчмуудыг баримтална", 6.22-т "Намын Их хурлын эрх, үүрэг: 6.22.4. Намын даргыг сонгох, ..." гэж тус тус зааснаас үзвэл намын даргыг сонгох эрх, үүрэг нь тус намын Их хуралд хадгалагдаж байна.

Иймд, Гэр хороолол хөгжлийн намын 3 дугаар Их хурлын "намын даргыг шинээр сонгох" үйл ажиллагаа нь хуулийн дээрх заалт болон тус намын Дүрэмд нийцсэн гэж үзэх үндэслэлтэй.

Гэр хороолол хөгжлийн намын Их хурлын 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор Батхуягийн Батсүхийн намын даргын бүрэн эрхийг дуусгавар болсонд тооцсон бөгөөд намын даргын сонгуульд Батхуягийн Батсүх, Чимэдбазарын Энхцэцэг нар нэр дэвшиж өрсөлдсөн, нууц санал хураалтаар Б.Батсүх 66 санал буюу 67.35 хувь, Ч.Энхцэцэг 32 санал буюу 32.65 хувийн санал тус тус авсан, улмаар намын даргаар Б.Батсүхийг сонгож баталсан нь өргөдөлд хавсаргаж ирүүлсэн баримтууд, Тооллогын комиссын мөн өдрийн 03, 07 дугаар тогтоолоор тогтоогдсон, намын даргыг сонгосон эдгээр үйл ажиллагаа нь Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг, Гэр хороолол хөгжлийн намын дүрмийн дээрх заалтуудад нийцсэн гэж үзлээ.

Гурав.Намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан талаар:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т "Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:", 17.2.1-д "намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах" гэж заасан.

Дээр дурдсанаар эрх бүхий этгээдээс зарласан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан Гэр хороолол хөгжлийн намын 3 дугаар Их хурлаар тус намын Дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн, мөн өдрийн 03 дугаар тогтоолоор “Намын дүрмийн өөрчлөлтийг бүхэлд нь баталсан” нь өргөдөлд хавсарган ирүүлсэн холбогдох баримтуудаар тогтоогдсон, энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1-д заасантай нийцэж байна.

Мөн Гэр хороолол хөгжлийн намын дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгаж зохицуулсан байх тул бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдсонгүй.

Иймд, Гэр хороолол хөгжлийн намын даргаар Батхуягийн Батсүхийг, мөн Гэр хороолол хөгжлийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэх нь зүйтэй байна.

Гэр хороолол хөгжлийн намын хөтөлбөр хуульд нийцсэн болохыг дурдав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан Гэр хороолол хөгжлийн намын даргаар Батхуягийн Батсүхийг бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Гэр хороолол хөгжлийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА